

## Шашны үл тэвчих байдал

### Эцэг эх, асран хамгаалагч, сурагчдад зориулсан мэдээлэл

#### Бидний зорилго

Манай байгууллага нь сурагчид, тэдний гэр бүл болон сургуулийн хамт олны соёлын, хэлний, шашны болон оюун санааны олон талт байдлыг хүндэтгэн дээдэлдэг. Бид NSW мужийн улсын сургуулиудад аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгахыг зорьж байна.

#### Шашны үл тэвчих байдал гэж юу вэ?

Шашны үл тэвчих байдал гэдэг нь хэн нэгнийг шашин шүтлэг, итгэл үнэмшил, оюун санааны үзэл бодлоос нь болж шударга бусаар, дорд үзэн эсвэл ялгаварлаж харьцах явдал юм.

#### Сурагчид шашны үл тэвчих байдлын хүрээнд гарсан зөрчлийг хэрхэн сургуульдаа мэдэгдэх вэ?

Хэрэв сурагч шашны үл тэвчих байдалтай холбоотой асуудалд өртсөн бол багш эсвэл сургуулийн ажилтанд хандаж мэдэгдэх хэрэгтэй. Мөн сургуулийнхаа цахим хуудас дахь холбоо барих мэдээллийг ашиглан утсаар холбогдох, эсвэл имэйл бичиж болно.

Зарим тохиолдолд шашны үл тэвчих байдал нь арьс өнгөөр ялгаварлах шинжтэй байж болно. Ийм нөхцөл байдал үүсвэл сургуулийн ажилтанд, эсвэл сургуулийн [Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлтэй тэмцэх ажилтанд](#) (Anti-Racism Contact Officer) мэдэгдэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг [Арьс өнгөөр ялгаварлан гадуурхлыг мэдэгдэх](#) (Reports of racism) болон [Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого](#) (Anti-racism policy) хуудаснаас үзнэ үү.

#### Энэ талаар сурагчдад зориулсан ямар дэмжлэг байдаг вэ?

Шашны үл тэвчих байдалд өртөх эсвэл гэрч болох нь сурагчдад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байдаг. Сурагчдад зориулсан мэдээлэл, дэмжих үйлчилгээ дараах вэбсайтуудад бий:

- [Сурагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийн дэмжлэг](#) (Mental health support for students)
- [Сургуулийн орчин дэх дээрэлхэлтийн эсрэг мэдээллийн хуудас](#) (Student anti-bullying pages)

## Эцэг эх, асран хамгаалагч болон ард иргэд шашны үл тэвчих байдалтай холбоотой тохиолдлыг хэрхэн мэдээлэх вэ?

Эцэг эх, асран хамгаалагч болон ард иргэд өөрийнхөө нэрийн өмнөөс, эсвэл сурагчийн зөвшөөрлөөр түүний нэрийн өмнөөс шашны үл тэвчих байдлын талаар мэдээлэл өгч болно.

Уг мэдээллийг тухайн явдал болсон сургуульд өгөх ёстой. Эцэг эх, асран хамгаалагчид сургуулийн цахим хуудас дахь холбоо барих мэдээллийг ашиглан биечлэн, имэйлээр эсвэл утсаар мэдээлэл өгөх боломжтой.

Хэрэв сургуультай холбогдоход танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол 131 450 дугаарт холбогдож, операторт өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсч залгах утасны дугаараа хэлнэ үү. Энэ үйлчилгээ үнэ төлбөргүй болно.

## Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан ямар дэмжлэг байдаг вэ?

Эцэг эхчүүдэд зориулсан мэдээлэл, дэмжих үйлчилгээний талаар дараах вэбсайтаас авах боломжтой:

- [Сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын дэмжлэг](#) (Mental health and wellbeing support)
- [Эцэг эхчүүдэд ямар дэмжлэг үзүүлэх боломжтой вэ?](#) (What support is available to parents?)

## Дараагийн алхмууд

Нэмэлт дэмжлэг авах эсвэл тухайн үл тэвчих байдал өргөн хүрээнд тохиолдож байна гэж үзэж байвал Шашны Үл Тэвчих Байдлын шугамын 1300 679 332 дугаарт залгаж, операторт энэ дуудлага шашны үл тэвчих байдлын талаар мэдэгдэнэ үү. Шаардлагатай бол утсан орчуулгын үйлчилгээг ашиглаж болно. Уг шугаманд холбогдсоноор дараах дэмжлэгийг авах боломжтой:

- холбогдох бодлого, журмын талаар мэдээлэл авах
- мэдүүлгийг холбогдох газруудад шилжүүлэх
- зохих тусламж үйлчилгээнтэй холбогдох
- мэдүүлгийн дагуу шударга шийдвэр олж мэдэх.

## Гомдол гаргах

Сурагчид, эцэг эх, асран хамгаалагчид [Гомдол гаргах хураангуй гарын авлага](#) (quick reference guide for making a complaint) -ын дагуу гомдол гаргах боломжтой. Дэмжлэг үзүүлдэг байгууллага, [дэмжигчийн талаарх мэдээлэл](#) (support persons and advocates) гэсэн орчуулсан хуудаснаас гомдол гаргах үйл явцын талаар дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

## Холбогдох хэлтсийн бодлого журмууд

- [Арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг бодлого](#) (Anti-racism policy)
- [Олон соёлт боловсролын бодлого](#) (Multicultural education policy)
- [Сурагчийн зан авирын бодлого](#) (Student behaviour policy)